

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ



**ТОМООХОН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ  
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ  
2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

### Аудитыг гүйцэтгэсэн:

#### ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал: Б.Баттуяа

Хоёрдугаар хэлтсийн захирал, менежер:

Г.Гүнжидмаа

Нэгдүгээр хэлтсийн Ахлах аудитор Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор Д.Цэрэндорж  
З.Ариунзаяа

Аудитор Ш.Энхтайван  
Ц.Цолмон  
Л.Авирмэд  
С.Одонцэцэг  
Ж.Оюунтуяа  
М.Доржмаа

*Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 263755, 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.*

#### ХАЯГ:

Үндэсний аудитын газар  
Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3,  
Засгийн газрын IV байр  
Улаанбаатар хот 15160  
МОНГОЛ УЛС

### АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт ..... 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл ..... 4

#### Бүлэг 1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт

Оршил ..... 5

▪ Үндсэн чиглэлийн төлөвлөлт, бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна ..... 5

▪ Шалгуур, хүрэх түвшин үр дүн, хөрөнгийн эх үүсвэр оновчтой тогтоогдохгүй байна ..... 6

▪ Бэлтгэл хангагдаагүй, хэрэгжих баталгаа сул арга хэмжээг батлуулсан байна ..... 8

#### Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ

Оршил ..... 10

▪ Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангахуйц үр нөлөөтэй ажил дутагдаж байна ..... 10

▪ Томоохон ажлуудын биелэлтэд анхаарал тавьж ажиллахгүй байна ..... 11

▪ Бодлогын яамд, газруудын ажлын зохион байгуулалт сул, уялдаа холбоогүй нь хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна ..... 12

#### Бүлэг 3. Үндсэн чиглэлийн биелэлт, түүний тайлагнал

Оршил ..... 13

▪ ЭЗХЯ үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 73.0 хувь гэж дүгнэжээ ..... 13

**Агуулга**

–Үргэжлэл–

- Макро түвшний зарим үзүүлэлт бүрэн биелэгдээгүй байна 13
- 2012 дэвшүүлсэн дийлэнх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дутуу байна ..... 15
- Үндсэн чиглэлийн биелэлтийг зохих ёсоор тайлагнахгүй байна ..... 16
- Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнд хүрээгүй байна . 19
- ҮАГ-ын зөвлөмжийг ТЕЗ-д хангалтгүй хэрэгжүүлсэн байна 19

**Аудитын дүгнэлт ..... 20**

**Холбогдох байгууллагын санал:**

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санал ..... 21
- Эдийн засгийн хөгжлийн яамны санал ..... 23

**Саналд өгсөн тайлбар ..... 24**

**Аудитын зөвлөмж ..... 25**

**ХАВСРАЛТУУД:**

- Хавсралт №1 ..... 26*
- Хавсралт №2 ..... 28*
- Хавсралт №3 ..... 29*

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ ..... 30**

## Товчилсон үгийн жагсаалт

<b>БОНХЯ</b>	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БХЯ</b>	Батлан хамгаалах яам
<b>ГАГ</b>	Гүйцэтгэлийн аудитын газар
<b>ГХЯ</b>	Гадаад харилцааны яам
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЗГХЭГ</b>	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
<b>ЗГҮАХ</b>	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
<b>ЗТЯ</b>	Зам, тээврийн яам
<b>МШХХТГ</b>	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
<b>НЗДТГ</b>	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
<b>ӨЧҮ</b>	Өрсөлдөх чадварын үзүүлэлт
<b>СЗХ</b>	Санхүүгийн зохицуулах хороо
<b>ССАЖЯ</b>	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
<b>ТЕЗ</b>	Төсвийн Ерөнхийлөн захирагч
<b>ТХХТ</b>	Төр, хувийн хэвшлийн түншлэл
<b>ТӨХ</b>	Төрийн өмчийн хороо
<b>ТЭЗҮ</b>	Техник, эдийн засгийн үндэслэл
<b>ХАХНХЯ</b>	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
<b>ХБГ</b>	Хүлээгдэж буй гүйцэтгэл
<b>ХЗЯ</b>	Хууль зүйн яам
<b>ХХО</b>	Хувийн хөрөнгө оруулалт
<b>ХШУДАГ</b>	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>УУЯ</b>	Уул уурхайн яам
<b>УАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ҮХААЯ</b>	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
<b>ҮХЦБ</b>	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”
<b>ЦДАШ</b>	Цахилгаан дамжуулах агаарын шугам
<b>ШСАА</b>	Шадар сайдын ажлын алба
<b>ЭЗХЯ</b>	Эдийн засгийн хөгжлийн яам
<b>ЭХЯ</b>	Эрчим хүчний яам
<b>ЭЗНХҮЧ</b>	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /Үндсэн чиглэл/
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд доорх чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Үндсэн чиглэлийн төлөвлөлт оновчтой хийгдсэн эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж үр дүнг тооцсон эсэх.

### **Хамарсан хүрээ**

Аудитад Улсын Их Хурлын 2011 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадыг хамруулав.

### **Арга зүй, стандартын талаархи мэдэгдэл**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланг судлах,
- Хөрөнгийн эх үүсвэрийн уялдааг судлах, гүйцэтгэлийг харьцуулах, асуулга авах,
- Холбогдох төрийн байгууллагын албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судлах,
- Хэрэгжилт, гүйцэтгэлийн тайланг судлах, ҮАГ-аас 2011, 2012 онд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, санал асуулгын дүнг нягтлах, ярилцлага хийх,
- Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн статистик мэдээлэл, төрөөс баримтлах бодлогын баримт материалд тулгуурлан судалгаа хийх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах,
- ТЭЗ бүрээр аудитын урьдчилсан тайланг бэлтгэж, хэрэгжилтийн байдлыг танилцуулах.


Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитыг ҮАГ-ын ГАГ-ын Нэгдүгээр хэлтсийн аудитор, шинжээч нар гүйцэтгэв.

## Бүлэг 1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт

### Оршил

Эдийн засгийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт<sup>1</sup> “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хэтийн дунд, **богино** хугацааны стратеги, үндсэн чиглэл, ... үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, мөн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах ...” зэрэг үндсэн чиг үүрэг тусгагджээ.



### Үндсэн чиглэлийн төлөвлөлт, бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна

1.1 УИХ-аас баталсан эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 6 бодлогын хүрээний нийт 21 зорилтын 145 үндсэн арга хэмжээ<sup>2</sup> тусгагдсан байна.

1.2 Засгийн газрын тогтоолоор баталсан 2012 оны үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөнд нийт 329 дэд арга хэмжээг<sup>3</sup> хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №1.1

Д.д	Бодлогын хамрах хүрээ	УИХ-ын 39 дүгээр тогтоол		ЗГ-ын газрын 371 дүгээр тогтоол
		Зорилт	Арга хэмжээ	Дэд арга Хэмжээ
1	Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх макро эдийн засгийн бодлого	2	10	19
2	Өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит салбарын хөгжлийн бодлого	5	53	109
3	Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн	3	16	46
4	Хүний хөгжлийг хангах нийгмийн бодлого	5	32	90
5	Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд	4	20	21
6	Гадаад бодлого, батлан хамгаалах	2	14	44
<b>Нийт</b>		<b>21</b>	<b>145</b>	<b>329</b>

1.3 2012 оны үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь өмнөх жилүүдийнхээс тооны хувьд багассан байна. Тухайлбал, 2010 онд 473, 2011 онд 190 арга хэмжээ байсан бол 2012 онд 145 болж буурчээ. Мөн Засгийн газраас баталсан дэлгэрэнгүй төлөвлөгөөнд 2010 онд 567, 2011 онд 456 дэд арга хэмжээ тусгагдаж байсан бол харин 2012 онд 329 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцож төлөвлөсөн арга хэмжээний тоо буурчээ.

1.4 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг ТЕЗ-дын саналд тулгуурлан ач холбогдлоор нь эрэмбэлж, өмнөх жилүүдтэй харьцуулан чадавхи болон нөөцөд

<sup>1</sup> Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтын 2.5-ын “Үйл ажиллагааны стратеги зорилт”, 3.3-ын “Бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, үндсэн үүрэг, чиг үүрэг”,

<sup>2</sup> УИХ-ын 2011 оны 39 дүгээр тогтоол,

<sup>3</sup> Засгийн газрын 2011 оны 371 дүгээр тогтоол,

суурилан чанаргүй хэт олон арга хэмжээнээс зайлсхийж боловсруулсан гэж тайлбарласан.

1.5 Гэсэн ч үндсэн чиглэлд макро түвшний эдийн засаг, нийгмийн зарим арга хэмжээг эс тооцвол зорилт, арга хэмжээний хэрэгжилт нь олон жил үргэлжилсэн, зохих бэлтгэл хангагдаагүй, ажлын явцаар үнэлэхээр тооцсон, өмнөх жилүүдэд дутуу хэрэгжсэн бөгөөд давтагдсан шинжтэй, үндэслэл бага, тусгах шаардлагагүй арга хэмжээг давтан тусгасан байна. Жишээлбэл:

- “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулах”,
- “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах”,
- “Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлогын хүрээнд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх”,
- “Дулаан, цахилгааны шинэ эх үүсвэр бий болгох, станц барих”,
- “Боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх”,
- Хувийн хөрөнгө оруулалт болон ТХХТ-ийн хэлбэрээр хэрэгжүүлэх чиглэлээр тусгагдсан атлаа дэмжлэг туслалцаа тодорхойгүй ажлууд төлөвлөгдөж байна.

**Шалгуур, хүрэх түвшин, үр дүн, хөрөнгийн эх үүсвэр оновчтой тогтоогдохгүй байна**

1.6 2012 оны үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 3.5 их наяд төгрөгийн хөрөнгө санхүүгийн эх үүсвэр ашиглахаар байна. /Хүснэгт №1.2-ыг үзнэ үү/

Эх үүсвэр	Хүснэгт№1.2 /тэрбум төг/		Хувь
	Арга хэмжээний тоо	дүн	
Улсын төсөв	108	1 964,5	54,9
Гадаад эх үүсвэр	23	198,3	5,5
ТХХТ	4	440,5	12,3
ХХО	6	952,2	26,6
Орон нутгийн төсөв	1	2,8	0,08
Хүний хөгжил сан	2	23,0	0,7
БХАХ-ний төсөв	1	-	-
<b>ДҮН</b>	<b>145</b>	<b>3 581,3</b>	<b>100,0</b>

1.7 2012 онд ашиглахаар төлөвлөсөн санхүүгийн нийт эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 6.1 хувиар буурсан байна. Харин улсын төсвийн эх үүсвэр 1.9 их наяд төгрөг буюу 2011 онд төлөвлөж байснаас 5.4 дахин илүү хөрөнгө төлөвлөжээ.

1.8 Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар<sup>4</sup> 1,489.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба тодотголоор 1,208.4 тэрбум төгрөг батлагджээ.

1.9 Гэвч үндсэн чиглэлийн улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг 2012 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт, агуулгатай зэрэгцүүлэн үзэхэд 864.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 304.1 тэрбум төгрөгийн эх үүсвэр л батлагдаж, урьдчилсан гүйцэтгэлээр 223.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.<sup>5</sup>

1.10 Үндсэн чиглэлд тусгагдсан эх үүсвэр нь хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний 15.5, гүйцэтгэлийн 11.4 хувийг тус тус эзэлж байгаагаас үзэхэд үндсэн чиглэлийн ихэнх арга хэмжээ санхүүгийн эх үүсвэргүй байжээ.

1.11 Хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээ дутуу буюу хангалтгүй хэрэгжсэн шалтгааныг хөрөнгө санхүүтэй холбон тайлбарладаг ч төлөвлөлтийн шатанд хөрөнгө шаардсан арга хэмжээг ач холбогдлоор эрэмбэлж, үндэслэл, эх

<sup>4</sup>Эх сурвалж: Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн хавсралт “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт”

<sup>5</sup>Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн бодлогын газар, Хөрөнгө оруулалтын хэлтэс /хуучин нэрээр/

үүсвэрийг бодитой тооцоогүйгээс төсөв боловсруулах, хянаж батлах шатанд хасагдаж байна.

1.12 ТХХТ-ийн зарчмаар 440.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг төсөвлөсөн нь өмнөх оноос 1.6 их наяд төгрөгөөр буурсан бол ХХО-ын дэмжлэгийг 100 хувь ашиглаж чадвал 952.2 тэрбум төгрөгийн шууд хөрөнгө оруулалт хийгдэхээр тооцоолсон байна.

1.13 2011 оны үндсэн чиглэлд тусгагдсан дэд бүтцийн салбарт ТХХТ-ийн зарчмаар хэрэгжүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байсан бол 2012 онд давтагдаж байна.

1.14 Үндсэн чиглэлд гадаад эх үүсвэрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх нийт 23 арга хэмжээнд 198.3 тэрбум төгрөг төлөвлөсөн нь өмнөх оноос 2 дахин илүү бөгөөд 7.1, 7.2, 7.5, 7.7, 7.11 дэх арга хэмжээний хүрэх үр дүнгийн түвшин болох барилгын ажлын гүйцэтгэлийн хувь, ашиглалтад орох автозам, шугам сүлжээний урт зэрэг үзүүлэлттэй харьцуулахад хэрэгжих боломжгүй байна.

1.15 Үндсэн чиглэлд тусгагдсан ТХХТ-ийн зарчмаар болон ХХО-ыг татан оролцуулах замаар хэрэгжүүлэх гэсэн арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн, хүрэх түвшин, хариуцлага, зохион байгуулалтыг оновчтой болгож чадаагүйгээс төлөвлөсөн ажлууд он дамжин удааширсан хэвээр байна.

1.16 Улсын төсвийн 2012 оны хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилтийн ХБГ-ийг авч үзэхэд нийт хөрөнгө оруулалтад дотоодын эх үүсвэрээр 1,223.2 тэрбум төгрөг, үүнээс шууд хөрөнгө оруулалт 1,124.5 тэрбум төгрөг зарцуулсан байна<sup>6</sup>.

1.17 Эрүүл мэнд, боловсролын салбарын зорилт, арга хэмжээний төлөвлөлт стратеги зорилттойгоо уялдаагүй, хөрөнгө санхүүгийн төлөвлөлт оновчтой бус, төсөв батлагдаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардлын 80 гаруй хувийг өвчлөлийн дараах тусламж, үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн,
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх зэрэг нийгмийн эрүүл мэндийн асуудлыг тусгаагүй нь өвчлөлийн түвшинг бууруулах, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ орхигдуулсан,
- Эхийн эндэгдлийг өмнөх оныхоос нэмэгдүүлж төлөвлөсөн нь зорилтын агуулгыг алдагдуулсан,
- Бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендерийн мэдрэмжтэй болгох” гэсэн зорилт нь үйл ажиллагааны хэрэгжилтээр буюу хүрэх түвшинг 100 хувь гэсэн нь ямар ажил хэрхэн хийгдэж зорилтот түвшинд хүрэх нь тодорхойгүй,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, дээд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлэх зорилтын шалгуур нь аттестатчилалд хамрагдах сургуулийн тоо, дэлхийн нэр хүндтэй сургуулиас урих багшийн тоогоор тодорхойлжээ. Гэвч нэр хүндтэй сургуулиас эрдэмтэд урих нь тухайн сургуулийн гадаад хамтын ажиллагаа бөгөөд үндсэн чиглэлд тусгах албагүй юм

Мөн байгаль орчны салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаадаагүй зарим арга хэмжээг дурдвал:

- 8.2.2-ын “Хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах газрын станцын антенны цамхагийн зураг төслийн зардал 60.0 сая төгрөг”
- 8.7.2-ын “Туул голын сав газрын усны ордын нөөцийг үнэлэх ашиглалтын, хайгуулын, гидрогеологийн судалгаа явуулах, эх үүсвэрийн ашиглалтын зохистой горим тогтоох судалгааны ажил 0.5 тэрбум төгрөг”

<sup>6</sup> Эх сурвалж: Сангийн яам “Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийн товч танилцуулга”



- 8.7.3-ын “Полихлортбифенил агуулсан тоног төхөөрөмжийн хаягдлыг хадгалах байгууламж барих 1.3 тэрбум төгрөг”
- 8.7.6-гийн “Аюултай хог хаягдлын төвлөрсөн цэг шинээр байгуулах 1.2 тэрбум төгрөг”
- 9.1.6-гийн “Агаарын бохирдлын 2 эх үүсвэрийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх 1 тэрбум төгрөг”

Мөн зам, барилгын салбарт 2008 оноос хойш жил бүр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан ч хүрэх түвшинг бодитой тодорхойлоогүй, ТЭЗҮ, зураг төсөлгүй, худалдан авах ажиллагаа удааширсан, гүйцэтгэгч сонгон шалгаруулах явцад хууль зөрчсөн алдаа гаргасан, зам, барилга үйлдвэрлэлийн салбарт материал, түүхий эд, шатахууны үнийн өсөлт нөлөөлсөн зэргээс шалтгаалж хэрэгжээгүй ажлууд ч байна. Жишээ нь:

- Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт зорчигч тээврийн автовокзал барих ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Мөн гадаад харилцааны салбарын хувьд:

- “Хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэний хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, хилийн чанад дахь Монгол иргэдийн бүртгэлийг сайжруулах”, “Дипломат төлөөлөгчдийн газрыг өргөжүүлэн бэхжүүлэх зорилт”-ын хүрээнд Япон Улсад суугаа Элчин сайдын яамны барилгын төсөв хасагдсан, “Хөх хотод суугаа Ерөнхий консулын газрын шинэ байр барих” барилгын төсөв батлагдаагүй байна.
- Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганц мод, Шивээхүрэн-Сэхээ боомтыг олон улсын байнгын ажиллагаатай болгох, Монгол, Оросын Зэлтэр-Желтура, Бага Илэнхи гол-Айнэк голын боомтыг тохижуулах, хэвийн үйл ажиллагаанд оруулах арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар саатжээ.

## **Бэлтгэл хангагдаагүй, хэрэгжих баталгаа сул арга хэмжээг батлуулсан байна**

1.18 Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомж, эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох, ялангуяа хөрөнгийн зах зээл, санхүүгийн салбарын хөгжлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээрх арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй хийгдэж байна.

1.19 Тухайлбал, эрх зүйн орчны давхардал, зөрчлийн талаарх урьдчилсан судалгаа дутмаг, дотоод, гадаад хүчин зүйлсийн мэдээлэл бага, хэрэгцээ шаардлага, олон улсын гэрээ хэлэлцээр, мэргэжлийн болон техник, технологийн стандарт үзүүлэлтэд нийцсэн, үндэслэлтэй санал дүгнэлттэй эсэх нь тодорхойгүй бөгөөд ингэснээр тухайн хүрээний ихэнхи арга хэмжээний хэрэгжилт төсөл боловсруулсан, судалгаа хийсэн, ажлын хэсэг байгуулсан байдлаар л тайлагнагдаж байна.

1.20 Иймд үндсэн чиглэлд шинээр боловсруулж, батлуулж мөрдүүлэх эрх зүйн актыг тоогоор бус хуулийн нэр, агуулгаар нь тусгах, тухайн жилдээ батлагдаж мөрдөгдөж эхэлсэн байх, эсвэл түүний дараа жилээс хэрэгжиж эхлэхээр тодорхойлбол оновчтой юм.

1.21 Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, дэд бүтэц зэрэг их хэмжээний хөрөнгө санхүүгийн эх үүсвэр шаардсан салбарт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг үндэслэл бүхий хөгжлийн суурь болон харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглан төлөвлөхгүй байна.

1.22 ТЭЗ-д хөрөнгө оруулалтын шинж чанартай ТЭЗҮ, зураг төсөв, шийдвэр, эрх зүйн орчны бэлтгэл хангагдаагүй арга хэмжээг төлөвлөж байгаагаас хугацаа алдаж байна.

1.23 ТЕЗ-дын үйл ажиллагааны стратеги, бүтцийн нэгжүүдийн ажил, үйлчилгээтэй шууд холбоотой, бүтээгдэхүүн нийлүүлэлт, албан тушаалтны үр дүнгийн гэрээ зэргээр тодорхойлогдох чиг үүргийн шинж чанартай асуудал дийлэнх хувийг эзэлж байна.

1.24 Дунд хугацааны төсөл хөтөлбөрийн шинжтэй арга хэмжээг дараа жилийн үндсэн чиглэлд дахин тусгахдаа үр дүнд чиглэсэн хяналт-үнэлгээг хийж үндэслэл, тооцоо, тулгарсан хүндрэл бэрхшээлээс гарах арга замыг судалсны үндсэн дээр тусгаж байх нь зүйтэй. Тухайлбал,

- 3.1-ийн “Таван толгойн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс баяжуулах, хүнд аж үйлдвэр, эрчим хүчний цогцолбор байгуулах байгуулах ажлыг эхлүүлэх” зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тодорхой тооцоололгүй нэг жилийн хугацаанд цахилгаан станц, 3 үйлдвэр барих мэтээр төлөвлөжээ.
- 7.16-ын зорилт, арга хэмжээ нь 2010 оны Үндсэн чиглэлийн 5.5, 2011 оны Үндсэн чиглэлийн 7.10-ын арга хэмжээтэй агуулга нь давтагдсан, үр дүнгийн өөрчлөлт гараагүй, нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц барих ажлын бэлтгэл хангах зорилт, арга хэмжээ хандивлагч талтай тохирч чадаагүйгээс хэрэгжих боломжгүй болсон.
- Өмнөговь аймгийн хүн амын өсөлт суурьшилтай холбоотой цахилгаан эрчим хүчний шугамын дамжуулах чадлыг нэмэгдүүлэх шаардлагаар 35/10 кВ дэд станцыг 110/35/10 кВ-ын дэд станц болгон өргөжүүлэхээр хөрөнгийн эх үүсвэрийг 2013 оны төсвийн хуулинд 3,293.7 сая төгрөг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

## Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ

### Оршил

Эдийн засаг нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хариуцан хэрэгжүүлэгч байгууллага 18 байсан бол Улсын Их Хурлаас 2012 оны 8 дугаар сарын 16-ны өдөр баталсан “Засгийн газрын бүрэлдэхүүний тухай” хуулийн<sup>7</sup> дагуу 25 байгууллага үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээж байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ хэрэгжээгүй буюу дутуу хэрэгжсэн шалтгаан нөхцлийг аудитын явцад судалж үзэхэд:<sup>8</sup>

- “20.9” хувь төсөв, хөрөнгийн хүрэлцээгүйгээс,
- “22.8” хувь хамтран хариуцагч байгууллагын ажил, үйлчилгээ, хамтын ажиллагаанаас,
- “18.0” хувь бэлтгэл ажил бүрэн хангагдаагүйгээс,
- “9.7” хувь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн тодорхойгүйгээс,
- “7.1” хувь хэрэгжүүлэх нөөц, цаг хугацааны боломж хомс байдлаас шалтгаалжээ.

### Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангахуйц үр нөлөөтэй ажил дутагдаж байна

2.1 Зарим байгууллага үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтэд анхаарал хандуулаагүй, хэрэгжилтийг зохих ёсоор зохион байгуулаагүй байна. Тухайлбал,

- Эрүүл мэндийн салбарын 2012 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө байхгүй, хариуцан хэрэгжүүлэгч байгууллага тодорхой бус, яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнээс тусгаадаагүй байна.
- БСШУЯ /хуучин нэрээр/ биелэлтийг хангуулах хуваарь, хариуцсан алба нэгжийг томилоогүй, зарим арга хэмжээ оны сүүлээр зохион байгуулагдсан байна.
- ҮХЦБ-д заасан “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, түүнд туссан “Ашигт малтмал” хөтөлбөр батлагдаагүй, мөн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын геологийн даалгаврыг хэрэгжүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны хяналтын төсөв боловсруулахад баримтлах норм, нормативгүйгээс арга хэмжээний зардлын хяналт алдагдаж байна.
- Авто болон төмөр замын салбарт хэрэгжүүлэх судалгаа, шийдэл тодорхойгүй, хэрэгжих хугацаа бодитой бус, ТЭЗҮ зураг, төсөл боловсруулах, гүйцэтгэгчийн хүчин чадлыг зөв тооцож хуваарилаагүй, ажлыг үргэлжлүүлэх хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүйгээс биелэлт хангагдахгүй байна.
- Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, засвар шинэчлэлийг үргэлжлүүлэх дулааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр тусгасан зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнасан ажил алга байна.
- Сангийн яам болон ЭЗХЯ-ны хариуцсан гол зорилт, арга хэмжээний хэрэгжилт буюу улсын эдийн засгийн голлох үзүүлэлтийг хангах, асуудлыг шийдвэрлэх, зорилтот түвшний үзүүлэлтийн таамаглал, судалгаа тооцоолол муу байна.
- Түүнчлэн санхүү, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох Сангийн яам, Монголбанк, СЗХ-ны хамтарсан арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.
- ТХХТ-ийн зарчмаар хэрэгжүүлэх 3.1, 7.3, 7.4, 7.10 дахь арга хэмжээ нь Засгийн Газрын 2010 оны 198 тогтоолоор баталсан “Концессийн зүйлийн жагсаалт”-д тусгаагдаж ирсэн ч сонгон шалгаруулалт явагдаагүй байна.

<sup>7</sup> Монгол Улсын 2012 оны “Засгийн газрын бүрэлдэхүүний тухай” хууль

<sup>8</sup> Эх сурвалж: УАГ-аас хийсэн судалгааны үр дүн

## Томоохон ажлуудын биелэлтэд анхаарал тавьж ажиллахгүй байна

2.2 УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан.

2.3 Уг тогтоолоор эхний ээлжинд Даланзадгад-Тавантолгой-Зүүнбаян, мөн Сайншанд-Баруун-Урт-Чойбалсан чиглэлд төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2010 онд багтаан эхлүүлэх үүргийн дагуу Засгийн газраас 2008-2012 онд 8, 2012-2013 онд 4 удаа шинэ төмөр замтай холбогдох шийдвэр гарган зохицуулалт хийж ирсэн ч хариуцлага сул, шийдвэрт олон удаа өөрчлөлт орсон, хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил, ТЭЗҮ хийгдсэн боловч батлагдаагүй, барилгын ажил эхлээгүй, зогсонги байдалд орох, тасалдах явдал гарч хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.



2.4 Газрын тосны салбарт хэрэгжих бүтээн байгуулалтын ажил 2009 оноос эхлэн жил бүрийн үндсэн чиглэлд тусгагдаж ирсэн ч уг зорилт, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй байна.

2.5 2012 онд ашиглалтанд оруулахаар Халзан бүргэдэй-Солонготын даваа, Ярант-Ховд-Өлгий-Улаан байшинт, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн нийт 388 км хатуу хучилттай зам ондоо багтаж ороогүй нь ажлын хариуцлага, зохион байгуулалттай холбоотой байна.

2.6 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангалтгүй, зохион байгуулалт муугаас зарим арга хэмжээ хэрэгжихгүйд хүрч байна. Тухайлбал:

- “Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үндсэн судалгааг эхлүүлэх” гэсэн зорилтын хүрээнд 30-аас доошгүй төслийг хамруулж, санхүүжилтийн 60-аас доошгүй хувийг олгохоор заасан ч сонгон шалгаруулалт оны сүүл рүү явагдсан, зарим төсөл эхлээгүй,
- Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлогын хүрээнд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх гэсэн зорилтын хүрээнд дэд бүтэц, барилга байгууламжийн 20 хүртэл хувийг хэрэгжүүлнэ гэж заасан ч анх сонгосон газрын байршил өөрчлөгдсөнөөс бүх зүйлийг дахин эхнээс нь хийхээр болж хэрэгжээгүй,
- 2012 онд гадны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хадлан, газар тариалангийн зориулалттай 8400 тракторыг 27.9 сая ам.доллараар худалдан авч Тариаланг дэмжих сангаар дамжуулан худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан ч зээлийн ерөнхий хэлэлцээрээр зээлийн хүүг /2 хувь/ жил бүрийн 3 дугаар сарын 21 болон 9 дүгээр сарын 21-нд төлөх ёстой ч хүү төлөх тухай мэдэгдээгүй буюу Сангийн яамтай дамжуулан зээлдүүлэх гэрээг эцэслэн шийдвэрлээгүй,
- Мэдээлэл холбооны өндөр технологийн инновацийн кластер байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2012 онд шинээр ТЭЗҮ боловсруулах зорилт тавьсан боловч тайлант хугацаанд боловсруулж чадаагүй,
- Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт зорчигч тээврийн автовокзал барих ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлыг хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч ажилласан нь тодорхойгүй, холбогдох баримт материал алга байна.

2.7 Нийгмийн салбарын зарим зорилт, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- 11.5-ын “Хүүхэд хамгаалал” Үндэсний стратегийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд “Асрах газар”-аас гарч байгаа хүүхдүүдийг түр орон сууцаар хангах ажил хийгдээгүй,
- 2.5-ын “Тэтгэврийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгон хөгжүүлэх” арга хэмжээний хүрээнд “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль”-ийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан боловч хэлэлцэгдээгүй буцаагдсан,
- 4.4.2-ын заасан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр хэлбэрээр Хүний хөгжил сангаас хишиг, хувь хүртэх боломжийг бүрдүүлэх талаар холбогдох журамд өөрчлөлт оруулах” арга хэмжээний дагуу ажил хийгдээгүй,
- 14.4.4-ийн “Ахмад настны нийгмийн хамгаалал, асрамж, халамж, эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх” ажил хийгдээгүй байна.

**Бодлогын яамд, газруудын ажлын зохион байгуулалт сул, уялдаа холбоогүй нь хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна**

2.8 Томоохон зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах тодорхой шийдвэргүй, хариуцагч байгууллагуудын ажлын уялдаа холбоогүйгээс хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- 3.4-ийн Асгатын орд”-ыг 2012 онд эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэлийг хангах зорилт хувь нийлүүлэгч талтай тодорхой шийдэлд хүрч чадаагүй,
- 3.7-гийн “Төмрийн ордод түшиглэн хар металлургийн баяжуулах үйлдвэрийн цогцолбор байгуулах”, 3.8-ын “Зэс хайлуулах үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх” зэрэг арга хэмжээ өмнөх жилүүдийн үндсэн чиглэлд тусгагдаж байсан ч хэрэгжээгүй,
- Төмөр замын тээх хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ төмөр зам барих ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил, урьдчилсан ТЭЗҮ-г хийсэн боловч батлагдаагүй, барилгын ажил эхлээгүй,
- Үндэсний архивын шинэ цогцолбор барилгын ажлыг дуусгах, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах зорилтын хүрэх түвшинг Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, 4 тоног төхөөрөмжөөр хангахаар тодорхойлсон боловч дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй гэдэг шалтгааны улмаас барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй,
- Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг шахмал түлшээр ханган, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар агаарын бохирдлыг 30 хувиар бууруулах 9.1 зорилтыг ЗТБХБЯ /хуучин нэрээр/, НЗДТГ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэл, түүний тайлагналыг БОНХЯ хэрхэн бүрэн хариуцах нь тодорхойгүйгээс зарим арга хэмжээг тайлагнаагүй байна.

### Бүлэг 3. Үндсэн чиглэлийн биелэлт, түүний тайлагнал

#### Оршил

ЭЗХЯ-ны үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу<sup>9</sup> тус яамны ХШҮДАГ хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн тайлагналыг нэгтгэн үнэлгээ өгөх ажлыг, харин яамдын бүтцийн нэгж дэх ХШҮДАГ-ууд хэрэгжилтийн байдлын анхан шатанд хяналт хийж, үнэлгээ өгч байна.

#### ЭЗХЯ 2012 оны “Үндсэн чиглэл”-ийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 73.0 хувь гэж дүгнэжээ



3.1 ЭЗХЯ-наас 2012 оны “Үндсэн чиглэл”-ийн биелэлтийг “73.0” хувь гэж үнэлжээ.

3.2 Хэрэгжилтийн үнэлгээг бодлогын хамрах хүрээгээр харуулбал:<sup>10</sup>

Хүснэгт №3.1 /тоо, %/

Бодлогын хамрах хүрээ	Үндсэн чиглэлийн		Биелэлтийн хувь
	зорилт	арга хэмжээ	
I. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх макро эдийн засгийн бодлогын:	2	10	78.0
II. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит салбарын хөгжлийн бодлогын:	5	53	68.5
III. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлогын:	3	16	63.1
IV. Хүний хөгжлийг хангах нийгмийн бодлогын:	5	32	78.8
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлогын:	4	20	80.0
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах бодлогын:	2	14	75.0

3.3 Нийт 145 арга хэмжээнээс бүрэн биелсэн 26, 70-90 хувийн биелэлттэй 81, 10-50 хүртэл хувийн биелэлттэй 36, 2 арга хэмжээ хангалтгүй биелэлттэй гэж үнэлжээ. /Хүснэгт №3.2-ыг үзнэ үү/

3.4 Хангалтгүй гэж үнэлэгдсэн арга хэмжээ нь “Өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит салбарын хөгжлийн”, болон “Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн” бодлогын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд байна.

Хүснэгт №3.2 /тоо, %/

Биелэлтийн байдал	Арга хэмжээний	
	тоо	хувь
Бүрэн биелсэн,	26	17.9
“90” хувийн биелэлттэй	44	30.3
“70” хувийн биелэлттэй	37	25.5
“50” хувийн биелэлттэй	19	13.1
“30” хувийн биелэлттэй	16	11.0
“10” хувийн биелэлттэй	1	0.7
Хангалтгүй биелэлттэй	2	1.4

#### Макро түвшний зарим үзүүлэлт бүрэн биелэгдээгүй байна

3.5 Үндсэн чиглэлд тусгагдсан макро түвшний эдийн засаг, нийгмийн зарим үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:<sup>11</sup>

<sup>9</sup> Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоол

<sup>10</sup> Эх сурвалж: Эдийн засгийн хөгжлийн яам

<sup>11</sup> Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Эдийн засгийн хөгжлийн болон Сангийн яам

Хүснэгт №3.3

/тоо, %/

Д.д	Зорилт, арга хэмжээний Агуулга	Шалгуур Үзүүлэлт	Зорилт, арга хэмжээний	
			хүрэх түвшин	Биелэлт
1.1	Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	ДНБ-ий өсөлт	16.6 хувь	12.3
		1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ	3900 ам.долл	3 660
		ӨЧ-ийн үзүүлэлт	3.9 нэгж	3.87
		Ажилгүйдлийн түвшин	6.8 хувиас ихгүй	8.2
1.2	Инфляцийг бууруулах төсөв, мөнгөний бодлого баримтлах	Инфляцийн зорилтот түвшин, жилийн эцэст	9 хувиас ихгүй	14
1.3	Төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгах	ДНБ-д нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх %	29.8 хувьд хүргэх	34.9
		ДНБ-д нэгдсэн төсвийн нийт зарлагын эзлэх %	36.5 хувиас илүүгүй	42.5
		ДНБ-д нэгдсэн төсвийн алдагдлын эзлэх %	6.7	7.6
5.6	Хөнгөн, хүнсний үйлдвэрийн кластерүүдийг хөгжүүлэх стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх	Боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувийн жин, хувь	9.0	6.2
10.1	Орон нутгийн хөгжлийг эрчимжүүлж, хөгжлийн ялгааг багасгах	Орон нутгийн хөгжлийн ерөнхий индексийн улсын дундаж хэмжээ	0.411-д нэгжид хүргэх	Гараагүй
10.2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хөдөөгийн хөгжлийг сайжруулах	Нийгмийн үйлчилгээний жишиг нормативийн хэрэгжилт	30-аас доошгүй %-д хүргэх	Гараагүй
14.1	Хүнд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Ядуурлын түвшинг бууруулах арга хэмжээг үргэлжлүүлэх	35 хувиас ихгүй	Гараагүй*
20.7	Гадаадын хөрөнгө оруулагчдад үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл, мэдээллийн санг сайжруулж, хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлэх	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын Өсөлт	10 хувь	Гараагүй

\*Үндэсний статистикийн хорооноос уг үзүүлэлт гараагүй, тооцоолол хийж буй гэж мэдээлсэн.

3.6 Үндсэн чиглэлд тусгагдсан дээрх зорилт 2012 оны хүрэх түвшин, үр дүнд хүрч чадаагүй, зарим үзүүлэлтийн биелэлт гараагүй нь ТЕЗ-даас энэ чиглэлээр хийсэн ажлын үр дүнгийн үнэлгээг бууруулах нэг шалтгаан нөхцөл болж байна.

3.7 2012 онд хүрсэн байх түвшин, үр дүнгийн зарим үзүүлэлтийн гүйцэтгэл зорилтот түвшинд хүрч чадаагүй, өмнөх оны хүрч байсан түвшинтэй харьцуулахад эдийн засгийн ерөнхий үзүүлэлт буурч, өсөлт саарсан байна.<sup>12</sup> Тухайлбал,

- ДНБ-ий өсөлт 2011 онд 17.3 хувь байсан бол 2012 онд 12.3 хувьтай гарсан нь өмнөх оноос 5 пунктээр буурсан бөгөөд төсөөлж байсан түвшнээс 4.3 хувиар бага гарчээ.

<sup>12</sup> Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг өмнөх жилийн жилийн статистик үзүүлэлттэй харьцуулав.

- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3660 ам.доллар байгаа нь өмнөх оноос өссөн боловч зорилтот түвшинд хүрч чадаагүй байна.
- Ажилгүйдлийн түвшин 8.2 хувьтай гарсан нь өмнөх оноос 1.4 пунктээр илүү буюу зорилтот түвшнээс илүү гарч ажилгүйдэл нэмэгджээ.
- 2012 оны жилийн инфляци өмнөх оны жилийн эцсээс 14 хувиар өссөн, зорилтот түвшнээс 5 нэгж хувиар илүү байна.
- ДНБ-д нэгдсэн төсвийн алдагдлын эзлэх хувь 2011 онд 6.9 хувьтай байсан бол 2012 онд 7.6 хувьд хүрч нэмэгдсэн байна.
- Боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 6.2 хувьд хүрсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад өсөлт гараагүй, зорилтот түвшнээс 2.8 хувиар доогуур байна.

3.8 Зорилтот түвшинд хүрээгүй болон биелэлт нь хангагдаагүй, эцэслэн гараагүй зорилт, арга хэмжээний шалтгааныг тодорхойлж тайлбарлах ажлыг ЭЗХЯ хийгээгүй байна.

**2012 онд дэвшүүлсэн дийлэнх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дутуу байна**

3.9 ТЕЗ-д Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор<sup>13</sup> баталсан журам, аргачлалын дагуу үндсэн чиглэлийн биелэлтийг хувь тогтоон үнэлж байна.

3.10 Харин бид үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хүрэх түвшин шалгуур үзүүлэлттэй нь харьцуулж хэрэгжсэн, дутуу хэрэгжсэн, хэрэгжээгүй гэсэн гурван бүлэгт хувааж үзсэн болно.

3.11 Ийнхүү харьцуулан үзэхэд төлөвлөсөн нийт 145 арга хэмжээнээс хэрэгжсэн 17, хэрэгжилт дутуу 120, хэрэгжээгүй 8 байна<sup>14</sup>. /Хүснэгт №3.4-ийг үзнэ үү/

3.12 2012 оны биелэлтийн дүнд хэрэгжсэн арга хэмжээ 11.7 хувьтай байгаа бөгөөд түүнийг өмнөх онуудтай харьцуулахад 2011 оноос 17.7, 2010 оноос 20.4 пунктээр буурсан, хэрэгжилт дутуу арга хэмжээ 82.8 хувь буюу өмнөх онуудаас 18.3-19.6 пунктээр өссөн нь хэрэгжилтийн ерөнхий түвшин буурч байгааг харуулж байна. /Хүснэгт №3.5-ыг үзнэ үү/

Хүснэгт №3.4 /тоо/

Бодлогын хамрах хүрээ	Хэрэгжилтийн байдал, Үүнээс		
	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэгжээгүй
I. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх макро эдийн засгийн бодлогын:			
Тоо,	1	9	-
II. Өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит салбарын хөгжлийн:			
Тоо,	5	42	6
III. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн:			
Тоо,	-	16	-
IV. Хүний хөгжлийг хангах нийгмийн:			
Тоо,	2	29	1
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн:			
Тоо,	9	11	-
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах:			
Тоо,	-	13	1
<b>Дүн</b>	<b>17</b>	<b>120</b>	<b>8</b>

Хүснэгт №3.5 /тоо, хувь/

Үзүүлэлт	2010 он		2011 он		2012 он	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хэрэгжсэн	152	32.1	56	29.4	17	11.7
Хэрэгжилт дутуу	305	64.5	120	63.2	120	82.8
Хэрэгжээгүй	16	3.4	14	7.4	8	5.5

<sup>13</sup> Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан “Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”

<sup>14</sup> Эх сурвалж: УАГ-аас ТЕЗ-дын үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлагналд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс



3.13 ТЕЗ-даас ирүүлсэн тайлагнал, биелэлтэд ЭЗХЯ-ны өгсөн үнэлгээ болон ҮАГ-аас арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэснийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар харуулбал:

Хүснэгт №3.6

Яамд, агентлаг	Аудитын өмнө /хувиар/			Аудитын дараа /тоогоор/		
	Яамдын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ <sup>15</sup>	Тайлбар	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэгжээгүй
БОНХЯ	-	67.5	Үнэлгээ дутуу	-	12	-
ГХЯ	98.0	88.0	-	-	3	-
Сангийн яам	85.2	74.1	-	1	6	-
ХЗЯ	-	80.8	Үнэлгээ ирүүлээгүй	6	7	-
БХБЯ	77.8	78.3	-	2	4	-
БХЯ	66.7	70.0	-	-	5	1
БШУЯ	-	72.5	Үнэлгээ дутуу	-	11	1
ЗТЯ	53.0	54	-	-	7	2
ССАЖЯ	-	50.0	Үнэлгээ ирүүлээгүй	-	2	-
УУЯ	86.0	61.1	-	-	5	2
ҮХААЯ	88.1	87.1	-	1	15	-
Хөдөлмөрийн яам	93.3	90.0	-	-	5	-
ХАХНХЯ	90.0	87.1	-	1	5	-
ЭЗХЯ	62.5	70.6	-	-	12	-
ЭХЯ	67.5	62.5	-	2	4	1
ЭМЯ	-	70.0	Үнэлгээ тодорхойгүй	1	6	-
ШСАА	-	85.0	Үнэлгээ ирүүлээгүй	-	5	-
ЦЭГ	-	30.0	Үнэлгээгүй	-	1	-
ЗГХЭГ /ТАЗ/	-	60.0	Үнэлгээгүй	-	2	-
ТӨХ	-	90.0	Үнэлгээ дутуу	-	1	-
СЗХ	-	81.4	Үнэлгээгүй	-	1	-
МШХХТГ	85.0	80.0	-	3	1	-
БХҮХ	-	-	Татан буугдсан	-	-	1
Дүн	-	73.0		17	120	8

3.14 Зорилт, арга хэмжээний явц, хугацаа, үнэлгээ тодорхойгүй, ажлын давхардал гарсан, төсөв, хөрөнгө оруулалтын ажил уялдаагүй байсан тохиолдол Сангийн яам, ЭМЯ, БХБЯ, БОНХЯ, БШУЯ, ССАЖЯ, УУЯ, ЭХЯ, ШСАА, СЗХ, ТӨХ-ны тайлангаар илэрч байна.

### Үндсэн чиглэлийн биелэлтийг зохих ёсоор тайлагнахгүй байна

3.15 2012 оны үндсэн чиглэлийн нийт 145 арга хэмжээнээс давхардсан тоогоор 25 хэрэгжүүлэгч байгууллагын дангаар хэрэгжүүлэх 114, хамтран хэрэгжүүлэх 54 арга хэмжээ байгаа бөгөөд яамдын шинэчилсэн бүтцийн дагуу зарим арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан байгууллага өөрчлөгдөж, цөөнгүй зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд шилжсэн ч хэрэгжилтийг дутуу тайлагнах тохиолдол гарч байна.

- ЭЗХЯ-нд дангаар 1, хамтран хэрэгжүүлэх 7 арга хэмжээ байсан бол ГХЯ-наас 6, ШСАА-наас 1 асуудал нэмэгджээ.
- УУЯ-нд 9 арга хэмжээ нэмэгдсэн.

<sup>15</sup> Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу үнэлсэн үнэлгээ

- Хөдөлмөрийн яаманд хуучин яамдаас 6 гэх мэтээр шилжсэн өөрчлөлт оржээ.
- Оюуны өмчийн газрын хариуцсан асуудал ХЗЯ-наас ШСАА-нд шинэ бүтцийн дагуу харъяалагдахаар болсон.
- ХАХНХЯ 6 арга хэмжээг нэмж хариуцахаар болсон.
- ЭБЭХЯ-наас /хуучин нэрээр/ УУЯ болон ҮХАА-нд шилжиж хариуцаж буй гэх 3 арга хэмжээг тайлагнаагүй байна.
- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо 6.4 дэх арга хэмжээний хэрэгжилтийг гаргаагүй байна.
- Сангийн яам болон СЗХ 2.4, ХЗЯ болон МШХХТГ 16.1, Сангийн яам, ҮХААЯ, ХАХНХЯ-ны 5.3, 5.6, 14.2 дахь арга хэмжээ агуулгын хувьд давхардсан байна.

3.16 Зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин зөрүүтэй, биелэлт дутуу, танилцуулгагүй, мэдээллийн боловсруулалт хангалтгүй, үнэлгээ хийгдээгүй, огт өөр ажил бичигдсэн, бичлэг давхардсан, нэгтгэсэн дүгнэлт, үнэлгээгүй, хэрэгжүүлэлтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авах арга хэмжээг тусгаагүй, хамтран хэрэгжүүлэгч байгууллагад хариуцуулан үлдээсэн зэрэг алдаа дутагдал гарч байна.

3.17 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинж чанартай арга хэмжээнд тусгагдсан хөрөнгийг төсөвт тусгуулах, мөн тусгагдаагүй шалтгаан, төсөвлөгдсөн хөрөнгөөс хэдий хэмжээний хөрөнгө нь төсөвт тусгагдаж, тухайн арга хэмжээнд зарцуулсан тооцоо, гүйцэтгэлийн талаар тайлагнаж хэвшихгүй байна.

3.18 Үндсэн чиглэлийн зарим арга хэмжээний эх үүсвэр нь ТЕЗ-дын төсвийн багцын “төсөл арга хэмжээний зардал”, “хөтөлбөр төслийн дотоод санхүүжилт”, “төвлөрсөн арга хэмжээ”-ний зардлаар санхүүжигдэж байгаа ч зарцуулалт, гүйцэтгэлийг тайлагнаж чадахгүй байна.

3.19 Хувийн хэвшлийн болон төсөл, хөтөлбөрийн хүрээнд гадаад эх үүсвэрийг дайчилсан бүтээн босголтын арга хэмжээг хувь оролцоотой нь иж бүрэн тайлагнахгүй байна.

3.20 ТЕЗ-дын тайланд урьд онд хийгдсэн ажлуудаа дурдах, хүрэх түвшин, үр дүнд чиглүүлэхгүй, оновчтой тайлагнахгүй байгаа тул төлөвлөсөн ажлуудын биелэлтийг дүгнэхэд хүндрэлтэй байна.

- Түүнчлэн 3.1.3-ын шинээр барих 300-450 МВт-ын дулааны цахилгаан станцын ТЭЗҮ батлуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх дэд зорилт, арга хэмжээний биелэлтийг 2012 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар тайлагнахдаа хоёр өөр объектын ажлыг тайлагнасан,
- 7.18.3-ын дэд зорилт, арга хэмжээнд аймгийн төвүүдэд шинээр 5 дулааны эх үүсвэрийг хувийн хөрөнгө оруулалтаар барина гэж төлөвлөсөн бөгөөд тайландаа улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Хөвсгөл, Сүхбаатар аймгийн дулааны станц, дулааны шугам сүлжээний ажлын биелэлтийг тайлагнажээ.
- Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөний 3.9.4, 3.9.6-д тусгасан лабораторийн барилга баригдаж дуусаагүй байхад доторх тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг төлөвлөснөөс тоног төхөөрөмж нийлүүлэгч компаний гэрээний хугацаа хоцрох, нарийн багаж тоног төхөөрөмжийн хадгалалт, угсралтын ажилд хүндрэл гарсан байна.
- 2012 онд интернетэд 190 сургуулийг хамруулахаар тооцсон байтал 400 сургуулийг хамруулсан гэж тайлагнасан нь сүүлийн 4 жилийн тоо үзүүлэлт бөгөөд тайлант онд 78 сургууль хамрагдсан,
- Сургалтын орчныг сайжруулах зорилтын хүрээнд ерөнхий боловсролын 30 сургуульд лаборатори нийлүүлэхээр төлөвлөхдөө Кембрижийн тогтолцоог туршиж буй 30

сургуулийг хангахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр өөр бусад сургуульд тоног төхөөрөмж нийлүүлсэн тоо хэмжээгээр тайлагнасан байна.

3.21 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлтийг бодитой тайлагнах нөхцөлийг бий болгож, үнэн зөв тайлагнаагүй байна. Тухайлбал:

- 2012 онд улсын төсвийн хөрөнгөөр 145, “Тогтвортой амьжиргаа-2”, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр”-ийн “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах” төсөл, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 61, нийт 206 булаг шандны эхийг тохижуулж, хамгаалсан гэж тайлагнасан боловч гүйцэтгэлийг ирүүлээгүй байна.
- Цөлжилт хүчтэй илэрсэн 9 аймагт ой, цөлжилтийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн тендерийн бичиг баримтыг боловсруулсан боловч аймаг бүрт цөлжилтийн эсрэг арга хэмжээнд 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө хуваарилсан ч гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.
- 8.7.1-ийн “Туул голын экологийн нөхөн сэргээлт хийх, хаягдал, бохирдлын хуримтлалыг тогтоон цэвэршүүлж, саармагжуулах” ажлын хүрээнд “Цэвэр агаар” сангийн хөрөнгөөр Туул голын урсацыг байгалийн аясаар нөхөн сэргээн, нэмэгдүүлэх төслийн тендерийг 2012 оны 12 дугаар сарын 20-нд шалгаруулж тендерийн комиссын шийдвэрээр “Монгол ус” ТӨҮҮГ гүйцэтгэгчээр шалгарч 650.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон ба ажил эхлэлийн төдий байна.
- 3.9.6-д барилга байгууламжийн хийц, бүтээцийн газар хөдлөл судлалын сорил, шинжилгээний төв лабораторийн барилга угсралтын ажлын хэрэгжилтийг тайлагнаагүй, газар хөдлөлийн техник судалгааны ажлын биелэлтийг гарган 100 хувь гэж дүгнэсэн байна.

Нэг зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хэд хэдэн арга хэмжээнд давтан дурдаж тайланд оруулсан байна. Жишээ нь:

- 7.11-ийн Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд инженерийн дэд бүтцийг барихад гүйцэтгэсэн ажлын биелэлтийг 7.12-д,
- 7.15.4-ийн Баян-Өлгий аймгийн Өлгий хотын цэвэр, бохир усны төвлөрсөн шугамын өргөтгөл, бохир усны насосны станцын барилгыг барьж ашиглалтад оруулах арга хэмжээний биелэлтийг 7.15, 7.15.6-д,
- 7.15-ын Увс аймгийн Улаангом хотын цэвэр усны цагираг шугам, цэвэр усны 2 дугаар эх үүсвэрийн угсралтын ажлын биелэлтийг 7.15.6-д,
- 7.15-ын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэлийн ажлын биелэлтийг 7.15.6-д давхар тайлагнасан байна.

3.22 Худалдан авах ажиллагаа удааширнаас гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажил эхлүүлэх хугацаа оройтон улмаар он дамжихаас гадна авто зам, барилгын технологийн горим, стандарт норм зөрчигдөж чанаргүй ажил хийгдэж байна. Тухайлбал:

- Замын-Үүдэд баригдах зорчигч тээврийн авто вокзалын барилгын гүйцэтгэгч “Бридж констракшн” ХХК 2012 оны 10 сард барилгын ажлыг эхлүүлсэн ба байгаль орчин хөрс, гидрогеологийн шинжилгээ судалгааны дүгнэлтэд хөрсний усыг 5-6 метрийн гүнд тогтсон, барилгын суурийн ажлыг дулааны улиралд хийх нь тохиромжтой гэж заасныг зөрчиж суурийг 5 метр орчим ухаж, бетон цутгалтын ажлыг 11-12 сард хийсэн байна.
- Нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх, түүний зураг төслийг боловсруулахад хотын хуучин төлөвлөлт, барилга байгууламж болон орчны эмх замбраагүй байдал нөлөөлснөөс хүндрэл, нэмэгдэл зардал гарах, улмаар ажлын явцыг удаашруулах гол шалтгаан болж байна.
- Төв аймгийн Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын дэд бүтэц барих ажлын тендер “ЖАЙКА” байгууллагын дүгнэлтээр техникийн санал шаардлага хангахгүй байсан тул хүчингүй болжээ. Гүйцэтгэгч шалгараагүй тул 2012 онд агаарын хөлгийн

перрон байгуулах, зам талбайн хамгаалалтын хашаа барих ажлууд хийгдээгүй, үерээс хамгаалах далангийн барилгын ажил гэрээний дагуу 2012 онд дуусахаар байсан боловч он дамжин хэрэгжиж байна.

- 2012 онд орон нутгийн нисэх буудлын аэродромыг өргөтгөх, хүчитгэх ажил хэрэгжээгүй байна.
- Өмнөговь аймгийн Гурвансайханы нисэх буудлын шороон зурвасын ажил, Цогтцэций суманд “Энержи ресурс” компанийн хөрөнгө оруулалтаар баригдсан агаарын хөлгийн хөөрч, буух хайрган хучилттай зурвасыг хатуу хучилттай болгох ажил хойшлогдон 2013 онд хэрэгжүүлэхээр болсон байна.

### Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнд хүрээгүй байна

3.23 Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тодорхойлоогүйгээс биелэх боломжгүй зорилт, арга хэмжээ үндсэн чиглэлд тусгагдаж байна. *Тухайлбал:*

- 3.1-д Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн эрчим хүчний цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг шинээр байгуулах цахилгаан станц нэг гэж тодорхойлсон ч ТЭЗҮ боловсруулах түвшинд ажил хийгдсэн,
- 2012 онд Газрын тосны боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах үүднээс газрын тосны олборлолтыг 1.5 сая баррелиар нэмэгдүүлэх зорилт тавьсан ч хүрэх түвшинг хангаж чадаагүй,
- 2012 онд Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж өмнөх оноос 7.2%-иар буурч, азотын давхар исэл 3.2%-иар, том ширхэглэгт тоосонцорын агууламж 16.3%-иар ихэссэн, стандарт агууламжаас илүү гарсан дүгнэлтээс үзэхэд агаарын бохирдлыг 30%-иар бууруулах зорилтот түвшинд хүрээгүй,
- 18.10-ын “Үндэсний архивын шинэ цогцолбор барилгын ажлыг дуусгах, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах” зорилтын хүрэх түвшинг Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, 4 иж бүрдэл тоног төхөөрөмжөөр хангахаар тодорхойлсон боловч барилгын ажлын явц дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй гэдэг шалтгааны улмаас барилгын ажил 70.0 хувийн гүйцэтгэлтэй,
- Алтанбулагийн чөлөөт бүсийн дэд бүтэц, авто замыг барьж байгуулах ажлын хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэл зорилтот түвшинд хүрээгүй,
- Улсын хэмжээнд 2012 онд нийт 865 км хатуу хучилттай зам барьж ашиглалтад оруулахаас нийслэлд л 28 км зам шинэчлэн сайжруулж ашиглалтад оруулсан байна.
- Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд баригдах 100 мянган айлын орон сууцыг иргэдэд урт хугацааны зээлээр олгох ажлыг үргэлжлүүлж 16500 иргэнийг хамруулах гэж тооцсон ч 1142 иргэн хамрагджээ.

### ҮАГ-ын зөвлөмжийг ТЭЗ-д хангалтгүй хэрэгжүүлсэн байна

3.24 УИХ-ын даалгаснаар ҮАГ-аас Монгол Улсын 2010, 2011 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд аудит хийж энэхүү баримт бичгийг боловсронгуй болгох, арга хэмжээний хэрэгжилт, тайлагналд тавих хяналт, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх, зорилт, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тооцож байх зэрэг тодорхой асуудлаар зөвлөмж өгсөн ч ТЭЗ-д тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. /Зөвлөмжийн биелэлтийг хавсралт №3-аас үзнэ үү/

3.25 ЗГХЭГ болон ЭЗХЯ улсын эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн төлөвлөлт, тайлагнал, түүнийг үнэлэх асуудлыг нэгтгэн зангидаж, ТЭЗ-дын үйл ажиллагааг чиглүүлж зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна.

## Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний тоо өмнөх жилүүдээс цөөрсөн хэдий ч шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, санхүүгийн эх үүсвэр тэр бүр оновчтой тодорхойлогдоогүй байна.
- Үндсэн чиглэлийн арга хэмжээг үр дүнд чиглүүлсэн, хэрэгжих үндэслэл, санхүүгийн баталгаатай, биелэлтийг нь тооцох боломжтой байхаар боловсруулах стандарт, арга зүй шаардагдаж байна.
- Үндсэн чиглэлийн 145 зорилт, арга хэмжээний биелэлтийг тогтоосон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнтэй нь харьцуулан үзэхэд хэрэгжсэн 17, хэрэгжилт дутуу 120, хэрэгжээгүй 8 арга хэмжээ байна.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь төсөв, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажаагүй, хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй, бэлтгэлийг бүрэн хангадаггүй, цаг хугацаа, хүчин чадал, нөөцийг оновчтой тооцдоггүй, шийдвэр тогтвортой хэрэгждэггүйтэй гол төлөв холбоотой байна.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар болон хувийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, загвар тодорхойгүй, хэрэгжилт хангалтгүй байна.
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг санхүүжүүлсэн эх үүсвэрийн зарцуулалт, гүйцэтгэлийг тооцохгүй, биелэлтийг үнэн зөв, бодитой тайлагнахгүй байна.
- Үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын явцад төсвийн ерөнхийлөн захирагч нар төдийлөн ач холбогдол өгөхгүй, хяналт тавихгүй, үр дүнд чиглүүлэн удирдахгүй байгаа нь хариуцлагын тогтолцоо сул байгаатай холбоотой байна.
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд ҮАГ-аас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахгүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын хариуцсан асуудлыг бүртгэлжүүлэх, ил тод мэдээлэх, хэрэгжилт, тайлагналын явцад хяналт тавихуйц цахим мэдээллийн тогтолцоо үгүйлэгдэж байна.

## Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал:



### МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>13</sup> оу <sup>04</sup> дугаар  
сарын <sup>30</sup> ны өдөр

Дугаар ... *αэг/683*

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР  
А.ЗАНГАД ТАНАА

Аудитын тайлангийн тухай

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлантай танилцаад үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлантай холбогдуулан гаргасан танай дүгнэлтийг зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байна.

Жил бүрийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцыг Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам"-ын дагуу зохион байгуулж ирсэн билээ.

Энэхүү журмын дагуу Засгийн газар үндсэн чиглэлийн төслийг улс орны хөгжлийн стратеги, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж 5 дугаар сарын 1-ний дотор буюу улсын төсөв батлагдахаас нилээд хугацааны өмнө УИХ-д өргөн мэдүүлж батлуулж байна. Төсвийн тухай хуульд Үндсэн чиглэлийг УИХ-ын хаврын чуулганаар улсын төсөв батлагдахаас өмнө батлахаар заасан байгаа.

Аудитын зөвлөмжийн Ерөнхий сайдад зөвлөмж болгосон 2 дахь хэсэгт "Үндсэн чиглэлд батлагдсан зорилт, арга хэмжээний санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэгдсэн төсөв болон бусад бодлого, хөтөлбөртэй уялдуулан батлуулж байх" гэж заасан нь Төсвийн тухай хууль болон УИХ-ын 2010 оны 45, 2011 оны 39 дүгээр тогтоолд Үндсэн чиглэлд тулгуурлан төсвийн төслийг боловсруулж УИХ-аар батлуулахыг Засгийн газарт даалгасантай нийцэхгүй байгаа тул зөвлөмжийн уг заалтыг өөрчлөх нь зүйтэй байна.

Засгийн газраас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Энэ хуулийн төсөл батлагдсанаар аудитын дүгнэлтэд дурдагдсан үндсэн чиглэлийн төлөвлөлт, түүний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэхтэй холбоотой зохицуулалт бий болж, тайлан болон үнэлгээний чанар сайжрах болно.

Аудитын дүгнэлтэд "Цахим мэдээллийн тогтолцоо үгүйлэгдэж байна" гэж заасан. Засгийн газар шинэчлэлийн бодлогын хүрээнд дараахь ажлыг хэрэгжүүлж байна:

- НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем"-ийг боловсруулан эхний ээлжинд яам, Засгийн газрын зарим агентлагийн түвшинд турших ажлыг эхлүүлээд байна.

- "Төрийн байгууллагын дотоод удирдлагын систем"-ийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт амжилттай туршсан бөгөөд цаашид яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн төрийн байгууллагуудад нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Ч.САЙХАНБИЛЭГ

**Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн санал:**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН  
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 25-59-12, Факс: (976-11) 32-79-14,  
E-mail: info@med.gov.mn, http://www.med.gov.mn

2013.04.30. № 1/863  
танай -ны № -г

**Санал хүргүүлэх тухай**

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д танай байгууллагаас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төслийн 3.15-д "Яамдын шинэчилсэн бүтцийн дагуу зарим арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан байгууллага өөрчлөгдөж, цөөнгүй зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд шилжсэн ч хэрэгжилт болон тайлагнал эзэнгүй орхигдох тохиолдол гарч байна" гэсэн дүгнэлт гаргасан байна. Хариуцсан байгууллага өөрчлөгдсөн ч тайлагнал эзэнгүй орхигдсон тохиолдол гараагүй болно. Иймээс энэ заалтыг дахин хянах нь зүйтэй гэж үзэж байна.

Тайлбар  
1-ийг үзнэ үү.



Н.БАТБАЯР

0100882



## **Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:**

### **ҮАГ-ын тайлбар 1**

Аудитын тайлангийн төслийн 3.15 дахь хэсэгт холбогдох өөрчлөлт хийв.

## Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

### Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт:

- Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилтыг томъёолох, түүнд хүрэх арга хэмжээнүүдийг тодорхойлон хэрэгжих хугацаа, шаардагдах санхүүгийн болон бусад нөөцийг төлөвлөж баталгаажуулах, хэрэгжилт үр дүнг тооцох шалгуурыг тогтоох стандарт, арга зүйг бий болгож, дагаж мөрдөхөд чиглэсэн санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2012 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу арга хэмжээнүүдийг нягтлан үзэж, эдийн засаг нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг харгалзан биелэлтийг хангах арга хэмжээ авах,
- Үндсэн чиглэлийг хангалтгүй хэрэгжүүлсэн байгууллага, албан тушаалтанд ажлын хариуцлага тооцох тогтолцоо, эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний саналуудын томъёолол, үндэслэл, тооцоог сайтар нягтлан боловсруулж, шаардагдах санхүүгийн болон бусад нөөцөөр баталгаажсан, хүрэх үр дүн, түүнийг тооцох шалгуур нь тодорхойлогдсон зорилт, арга хэмжээг Үндсэн чиглэлд тусгаж байх,

### Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2012 оны Үндсэн чиглэлд тусгагдсан хэрэгжилт дутуу буюу хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний биелэлтийг нягтлан үзэж, ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг харгалзан биелэлтийг хангах арга хэмжээг авч ажиллах,
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн зохион байгуулалтыг сайжруулах, тайлагналын явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцож ажиллах,
- Үндсэн чиглэлд улсын төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн болон батлагдсан санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй уялдуулан үнэн зөв, бодитой тайлагнаж байх.

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д.д	Бодлого, зорилт, арга хэмжээ		Хариуцан хэрэгжүүлэгч
<b>НЭГ. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>			
Зорилт-2. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэх чиглэлээр ажиллаж, санхүүгийн салбарын хөгжлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглүүлнэ.			
1	2.2	Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг дэмжих	СЯ, СЗХ, ЭЗХЯ
<b>ХОЁР. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
Зорилт-4. Байгаль, цаг уурын эрсдэл даах чадвар бүхий эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн салбарыг хөгжүүлнэ.			
2	4.10	Таримал ургамлын үрийн шинэ сортыг нутагшуулах, үрийн чанар, хангамжийг нэмэгдүүлэх	ҮХААЯ
Зорилт-6. Шинээр бий болох суурьшлийн бүс, хүн амын нутагшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүс, орон нутгийг хөгжүүлнэ.			
3	6.1	Уул уурхайн хөгжилтэй уялдан шинээр бий болох хот, тосгоны хэсэгчилсэн, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	БХБЯ, ГХГЗЗГ
Зорилт-7. Уул уурхайн хөгжил болон өрсөлдөх чадварыг дэмжсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ.			
4	7.11	“Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд орон сууцны хорооллын инженерийн дэд бүтцийг барих	БХБЯ, Барилга хөгжлийн төв
5	7.13	Улаанбаатар хотод барих Их тойрог 220, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын магистраль шугам, дэд станцыг барьж байгуулах	ЭХЯ БХБЯ НЗДТГ
6	7.19	Тавантолгойн дулааны цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх	ЭХЯ
<b>ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Зорилт-13. Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хүн амд ээлтэй, тэгш, хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэнэ.			
7	13.3	Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх	ЭМЯ
Зорилт-14. Хөдөлмөрийн зах зээлийг олон улсын стандартын дагуу хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд хүн бүрийн оролцоог хангахыг үндсэн чиглэл болгон баримталж ажиллана.			
8	14.2	Хүний хөгжил сангаас иргэн бүрт хишиг, хувь хүртээх ажлыг оновчтой хэлбэрээр зохион байгуулж ажиллах	ХАХНХЯ
<b>ТАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ</b>			
Зорилт-16. Уул уурхайн хөгжилтэй уялдан шинээр бий болох суурин газарт мэдээлэл, харилцаа, холбооны үйлчилгээг хүргэн, түүний технологийн дэд бүтцийг сайжруулна.			
9	16.1	Орон зайн мэдээллийн нэгдсэн дэд бүтэц, хаягжилтын системийг бий болгох, төрийн мэдээллийн сан, сүлжээний дэд бүтцийг бүрдүүлэх	МШХХТГ
10	16.2	Уул уурхайн хөгжилтэй уялдаж хилийн боомт, худалдааны чөлөөт бүс зэрэг газрыг хамарсан өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, цогц удирдлага, хяналтын систем хөгжүүлэх	МШХХТГ
11	16.3	Сумдад цахим мэдээлэл түгээх сүлжээг байгуулах ажлыг үргэлжлүүлэх, үүрэн утасны үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах	МШХХТГ
12	16.4	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог сайжруулж, бүртгэл, мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, улсын бүртгэлийн үндсэн бааз суурийг бэхжүүлэх	ХЗЯ

Зорилт-18. Хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, хууль сурталчлах ажлыг иргэдэд оновчтой, үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулж ажиллана.			
13	18.2	Цагдаа, дотоодын цэргийг нийгмийн хэв журмыг хамгаалахад шаардагдах зориулалтын техник хэрэгслээр үе шаттайгаар хангах	ХЗЯ
14	18.3	Алслагдсан сум, суурин, нийслэлийн дүүрэг, хороодод цагдаагийн кобан, бичил хэсэг барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэх	ХЗЯ
15	18.6	Хил хамгаалах байгууллагын техник хангамж, зэвсэглэлийг шинэчлэх, холбоо мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх	ХЗЯ
16	18.7	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх байгууллагыг олон улсын жишигт хүргэх, гадаадын иргэдэд тавих хяналтыг боловсронгуй болгох	ХЗЯ
17	18.8	Хорих анги болон цагдан хорих байрны харуул хамгаалалтыг сайжруулах, орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	ХЗЯ

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д.д	Бодлого, зорилт, арга хэмжээ		Хариуцан хэрэгжүүлэгч
<b>ХОЁР. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
Зорилт-3. Бодит салбарын хөгжлийг дэмжиж, өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.			
1	3.7	Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордод түшиглэн хар металлургийн БҮЦ байгуулах төслийн бэлтгэлийг хангах	УУЯ, ҮХААЯ
2	3.8	Зэс хайлуулах үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх	УУЯ, ҮХААЯ
Зорилт-6. Шинээр бий болох суурьшлийн бүс, хүн амын нутагшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүс, орон нутгийг хөгжүүлнэ.			
3	6.4	Эдийн засгийн хөгжилтэй уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилж, хэрэгжүүлэх	БХҮХ
Зорилт-7. Уул уурхайн хөгжил болон өрсөлдөх чадварыг дэмжсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ.			
4	7.2	Замын-Үүд, Улаанбаатарт холимог тээврийн ачааны терминал, логистик төв байгуулах ажлыг үргэлжлүүлэх	ЗТЯ
5	7.3	Төмөр замын тээх хүчин чадлыг сайжруулах, стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг холбосон төмөр замын сүлжээг барьж байгуулах ажлыг үргэлжүүлэх	ЗТЯ, ТӨХ
6	7.16	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц барих ажлын бэлтгэлийг хангах	ЭХЯ
<b>ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ НИЙГМИЙН БОДЛОГО</b>			
Зорилт-11. Сургалтын орчныг олон улсын стандартад нийцүүлэхэд түлхүү анхаарч, бүх шатны боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлнэ.			
7	11.9	Албан бус боловсролын үйл ажиллагааг дэмжих	БШУЯ
<b>ЗУРГАА. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ</b>			
Зорилт-20. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж, эдийн засгийн чиглэлээр харилцаагаа өргөжүүлнэ.			
8	21.6	Бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчний анги, бүрэлдэхүүнийг оролцуулах, тэднийг техник хэрэгслээр хангах	БХЯ

**ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг харуулав.

Хэнд хандсан:	Зөвлөмжийн агуулга:	Хэрэгжилтийн байдал:
Монгол Улсын Ерөнхий сайдад:	<ul style="list-style-type: none"> <li>▪ Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,</li> <li>▪ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг боловсронгуй болгох, хариуцлагын тогтолцоог бий болгох талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.</li> </ul>	Хангагдаагүй
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргад: <i>/Хуучин бүтцээр/</i>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Үндсэн чиглэлийг боловсруулах, төлөвлөх шатанд “Төр-хувийн хэвшлийн түншлэл”-ийн зарчмаар хэрэгжих зорилт, арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх асуудлыг тодорхой болгох арга хэмжээ авах,</li> <li>▪ Эцсийн үр дүн гараагүй зорилт, арга хэмжээг хянан үзэж, дараагийн жилийн үндсэн чиглэл батлагдахаас өмнө Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт эргэн мэдээлж үр нөлөөг тооцох зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх,</li> <li>▪ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг бүртгэх, хэрэгжилт, тайлагналын бүтэц, тогтолцоог шинэчлэн үр дүн, үр нөлөөг харуулсан бүтцэд шилжүүлэх талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,</li> <li>▪ Үндсэн чиглэлийн бүс орон нутагт хэрэгжих зорилт, арга хэмжээний биелэлтийн байдалд аймаг, нийслэлийн төр захиргааны болон мэргэжлийн байгууллагаас тавих мониторинг-үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх талаар судалж, шийдвэрлүүлэх.</li> </ul>	Зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, төлөвлөсөн ажлуудыг дурдсан буюу үр дүн гараагүй байна.
Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт:	<ul style="list-style-type: none"> <li>▪ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн болон хүндрэлтэй асуудлын талаар Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон бусад холбогдох газруудад мэдээлж, хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлагнаж байх,</li> <li>▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, тайлагналд тавих дотоод хяналтыг тогтмол хийж, зорилт арга хэмжээний биелэлтийн үр дүнг тооцож ажиллах,</li> <li>▪ Үндсэн чиглэлд тусгагдсан тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, газруудаас бүс орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.</li> </ul>	Хэрэгжилтийг зөвхөн ЭЗХЯ, ҮХААЯ, БШУЯ тус тус ирүүлжээ. Гэвч зөвлөмж бүрэн хангагдаагүй байна.



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяа)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД